

2023

САНХҮҮ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

АГУУЛГА

01 Бидний тухай

Эрхэм зорилго	2
Үнэт зүйл	2
Үйл ажиллагааны зарчим	2
Түүхэн замнал	3

02 Бизнесийн үйл ажиллагаа

Бүтэц, орон тоо, хүний нөөцийн тоо, мэдээ	4
Санхүүгийн үр дүнгийн мэдээ	5-7
Онцлох үйл явдал	8-9
Гэрэлтүүлгийн зах зээлийн тухай	10
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт	11-14
Нийгмийн хариуцлага	15
Гүйцэтгэх удирдлагын баг	16
Хүний нөөцийн бодлого	17
Сургалт, хөгжил	18
Үйлдвэрлэл үйл ажиллагааны ололт, амжилт	19-20
Бидний харилцагчид	21
Бизнесийн үйл ажиллагааны биелэлт	22
Бизнесийн үйл ажиллагааны төлөвлөлт	23

03 Байгаль орчин, нийгэм засаглал

24

04 Компанийн засаглал

Компанийн ерөнхий мэдээлэл	25
Хувьцаа эзэмшигчид, түүний бүтэц	26
ТУЗ түүний бүрэлдэхүүн	27-28
ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан	29
ТУЗ-ийн хороод	30
ТҮҮ-ийн цалин, урамшуулал	31
Хувьцааны мэдээлэл	32
Ногдол ашгийн мэдээ	33-34

05 Санхүүгийн тайлан

Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл	35
Хараат бус аудиторын дүгнэлт	36-37
Санхүү байдлын тайлан	38
Орлогын дэлгэрэнгүй тайлан	39
Мөнгөн гүйлгээний тайлан	40
Өмчийн өөрчлөлтийн тайлан	41

01 БИДНИЙ ТУХАЙ

Эрхэм зорилго



Мэдлэгт суурилсан үнэ цэнэтэй
бүтээлээр дэлхий ертөнцийг
гэрэлтүүлнэ

Үнэт зүйл

Зөв засаглал

Бид хэрэглэгч бүрийн хүсэн хүлээдэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг, ажилтан бүр өсөж дэвждэг, аз жаргалтай ажлын орчин бий болгосон, хувьцаа эзэмшигчид ашиг хүртэх, ил тод, үнэнч шударга, зөв засаглалтай жишиг байгууллага мөн

Эрдэм мэдлэг

Бид мэдлэгийг хязгааргүйд тооцон цаг үргэлж суралцан, өөрсдийгөө болон баг хамт олноо хөгжүүлж, ухаалаг зөв сэтгэлгээтэй үнэн шударга замналыг бий болгон ажилладаг

Шинэ санаачилга, бүтээлч байдал

Бид үргэлж технологийн хөгжил дэвшил, асуудлыг шийдвэрлэх бүтээлч шийдэл бүхий санал санаачилгыг дэмжин бүтээгдэхүүн хөгжүүлэлтдээ нэвтрүүлэн ажилладаг

Хамтын хүч

Бид эерэг хандлагатай байж, хамтын хүчийг дээдлэгч хамт олныг бүрдүүлж, бүтээмж өндөртэй ажилладаг.

Үзэл баримтлал

- Хууль, дүрмийг чандлан сахиулан ажиллах
- Техник, технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг явуулах
- Хамтын хүч, бүтээлч сэтгэлгээ, шинэ санал санаачилгыг дэмжин ажиллах
- Эрүүл аюулгүй орчинг бүрдүүлж, ажилчдыг өсөн дэвших бодлого баримтлан ажиллах
- Харилцагч, хэрэглэгчийг инээмсэглэлээр угтаж, итгэлээр үдэх

01 БИДНИЙ ТУХАЙ

Түүхэн замнал

2011

Цахилгаан тоног төхөөрөмж угсралт, суурилуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдав

2014

Лед гэрлийн үйлдвэрийг барьж, ашиглалтад оруулав

2017

Хувьцаат компани болж Монголын хөрөнгийн зах зээлд хөл нийлүүлэв

2019

Шинэ үйлдвэрлэл, оффисын байрыг ашиглалтад оруулав

2019

Байгальд ээлтэй дэвшилтэд технологи нэвтрүүлсэн байгууллагаар шалгарч “Ногоон гэрчилгээ” олгов

2020

Гэрлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд “Гост стандарт”-ыг нэвтрүүлэв

2021


Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагаар магадлан итгэмжлэгдэв




02 Бизнесийн үйл ажиллагаа

Бүтэц бүрэлдэхүүн, хүний нөөцийн тоо мэдээ

2023 онд бид 4 алба, 31 орон тоо бүхий бүтцийг батлан 4 алба, 24 ажилтан албан хаагчтай үйл ажиллагаагаа үргэлжлүүлэв.




Хүйсийн харьцаа




Ажиллаж буй чиглэл



Боловсролын байдал




Ажилласан жилийн байдал




02 Бизнесийн үйл ажиллагаа

Санхүүгийн үр дүнгийн мэдээ


Компанийн нийт борлуулалтын орлого 2,129 сая.төг




Үйл ажиллагааны зардал /сая,төг/



Цэвэр ашиг /сая,төг/




Үндсэн хөрөнгийн хэмжээ /сая төг/



02 Бизнесийн үйл ажиллагаа

Санхүүгийн үр дүнгийн мэдээ


Нийт төлсөн татвар 299,1 сая.төг




02 Бизнесийн үйл ажиллагаа

Санхүүгийн үр дүнгийн мэдээ


Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн 11,638 ширхэг



Суурьлуулалт, засвар үйлчилгээний томоохон 13 ажил






Үсгэн хаяг үйлдвэрлэл-9




02 Бизнесийн үйл ажиллагаа

Онцлох үйл явдал

Манай компанийн залуу инженерүүд ургамлын гэрлийн шинэ шийдлийг гарган хэрэглэгчдэд хүргэв. Энэхүү гэрэл нь ургамлын ургац, гарцыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдол өгч хэрэглэгчдэд ихээхэн сэтгэл ханамжийг бий болгосон бүтээл болж чадсан бөгөөд манай ургамлын гэрлийг одоо Орхон аймгийн тариаланч, ногоочид, И-март нарийн ногоо үрсэлгээ, тариалалт дээр ашиглан, харилцан хамтран ажиллаж байна.



Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д LED гэрэлтүүлэг шинээр нэмэгдэн оров.


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ
Дотоод 113
Улаанбаатар хот

2025 оны 03 сарын 29 өдөр

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭГТ, ӨӨРЧИЛӨТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төрийн болон өрөөн зурвасын өмчийн ирэнхүүр бараа, өмч, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10¹/2-т заагч үндэслэл МОНГОЛ Улсын Засгийн газрын ТОГТООЛ юм.

1. Жигдэвтэр шимтэй бэлэн тухай" Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 90 дугаар тогтоолын заваргаар баталсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д дөр дарааг агуулжтай дараахыг нэмэж, дэд заалт нэмжээ:
 - 1.2 дая заалтын 2.10, 20, 21 дг дэд заалт;
 - 2.10 Тусгай хэрэгшлэлийн тусгай;
 - 2.11.1 Галуурын элсээр хөрвөх."
 - 21.8 дая заалтын 8.13, 8.14 дг дэд заалт;
 - 8.13 Но болонжуулах үйлдвэрлэсэн нохой, муурын хоол;
 - 8.14 Мөчлөг илгэн гандлааг хөрвөх."
 - 31.11 дг дэд заалтын 11.15, 11.16 дг дэд заалт;
 - 11.15 Лампы тос, парфум;
 - 11.16 Галчын өрөг."
 - 41.10 дая заалтын 13.7 дг дэд заалт;
 - 13.7 Галуурын элсээр."
- 5.15 дая заалт;
- 5.15 Гэрэл гэрэлтүүлэх төхөөрөм, од өнгө;
- 5.15.1 LED гэрэл, гэрэлтүүлэг, гудамжны гэрэлтүүлгийн шил, бүх төрлийн гэрэлтүүлэг, түүний сахиу хангамж болон дагалдан хэрэгсэл."

2. Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан тохирлын баталгаатай барааны жагсаалтын 2.1 дг дэд заалтын "Малгай" гэсний дараа "Тусгай, саван, хэвдэг" гэж, 2.2 дая заалтын "Хатгал" гэсний дараа " Бүх төрлийн нийл урванд, дотуу" гэж, 2.4 дг дэд заалтын "Хүл" гэсний дараа " урванд, уут гэрлэг, снэгд, өмдөл, өмч хөрвөх гэж мэг" гэж, мөн заалтын "Хатгал" гэсний өмч "Хөвсгөрөн бутардагч" гэж, 2.5 дая заалтын "Тосго" гэсний дараа "Тосгоны, мөчлөг, галуурын, тусгай хэрэгшлэлийн, асар, шиддэгийн гэж мэг" гэж, 4.4 дг дэд заалтын "Бэлэн" гэсний дараа " нэг шиддэгийн хажвалалтын комбинаци, сонголт нэгжлэвчлэ чөлөөт бэлэн" гэж, 8.10 дая заалтын "Бодол" гэсний дараа "Тусгай нэг нэгжлэлийн далаа болонжуулах үйлдвэрлэсэн бодол, сонгоно нохойн бодол гэж мэг" гэж, 11.4 дг дэд заалтын "Хойвал" гэсний дараа "Хэрэг бүх төрлийн" гэж, 11.7 дая заалтын "Хатгал" гэсний дараа " хатгалд дугуйн далаа болонжуулах, үйлдвэрлэсэн бүх төрлийн рожон бүтээгдүүр" гэж, 11.12 дая заалтын "Сал-фетин" гэсний дараа " саван" гэж, 12.14 дг дэд заалтын "Хатгал" гэсний дараа " хэрэгшлэлийн бэлэн, гэмдэг бэлэн бэлэн" гэж, 12.20 дая заалтын "Сэлтэмн шил" гэсний дараа "сэлтэмн шил, барилгын дотор уусгагчид шилэн хавь, хавьга, шилэн бэлдэг, өлсөт үет шил ба өлсөт үет агуулгы шил, нарийн шилэн бэлч, шилэнгэжлийн шил, шилэн фидаа, далаа болонжуулах шилэн хийж дэлгэцүү" гэж, 12.26 дая заалтын "Хатгал" гэсний дараа " үрлэн, бүтэц асарфан, сэлтэмн шилэн бэлэн, хөвсгөр бэлэн, бэлтгэсэн чулуулаг, бэлтгэн агуулж" гэж, 14.2 дая заалтын "Хөвд" гэсний өмч "Хүл" гэж, "Хөвд" гэсний дараа "Түүх" гэж, мөн заалтын "Тусгай" гэсний дараа "Төхөөр, тавир" гэж тус тус нэмжээ.

3. Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалтын 2.9 дг дэд заалтын "Төхөөр хөвдөх хөвд" гэсний "Төхөөр хөвдөх бэлэн хэрэг зэргийн шилэн, шилэн, шилэн, шилэн бүх төрлийн хавьд, нэгч, чавар гэж мэг" гэж өөрчилжээ.

4. Энэ тогтоол гарсантай холбоотуулан "Жигдэвтэр бэлэн тухай" Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 336 дугаар тогтоолыг хүчингүй болгоход тооцожээ.



02 Бизнесийн үйл ажиллагаа

Онцлох үйл явдал

“2023 оны 06 сарын 15, 16-ны өдрүүдэд Хамтдаа Эрдэнэтэд хөгжье-2023 эдийн засгийн форум”-д амжилттай оролцлоо.


БНСУ-аас форумд оролцохоор ирсэн зочид, төлөөлөгч нар манай компаниар зочлон ирж цаашдын хамтын ажиллагааны эхлэлийг тавьснаас гадна хамтын ажиллагааны хүрээнд манай компанийн төлөөлөл 11-р сард БНСУ-д айлчлан уулзалт, хэлэлцээр хийгээд ирлээ



Эдийн засгийн форумд оролцсон зочид төлөөлөгч нар манай компаниар зочлон ирэх үеэр



11 сард ирсэн Бизнес уулзалтын хэсгээс...



Манай бүтээгдэхүүнүүд нь “Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн” ангилалд багтаж хэрэглэгч харилцагч нар маань хүссэн бүтээгдэхүүнээ Хаан банк, Хас банкны ногоон зээлийн санхүүжилтээр авах боломжтой боллоо.



Гадна болон дотор гэрэлтүүлгүүд



02 Бизнесийн үйл ажиллагаа

Гэрэлтүүлгийн зах зээлийн тухай

TrendForce-ийн "2021 оны дэлхийн гэрэлтүүлгийн LED ба LED гэрэлтүүлгийн зах зээлийн төлөв байдал-2021" тайланд дурдсанаар, LED ерөнхий гэрэлтүүлгийн зах зээлд иж бүрэн гэрэлтүүлгийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж, LED ерөнхий гэрэлтүүлэг, цэцэрлэгжүүлэлтийн буюу ургамлын гэрэлтүүлэг, ухаалаг гэрэлтүүлгүүд өсөн нэмэгдсээр байна.



Дэлхийн гэрэлтүүлгийн зах зээлийн хэмжээ 2022 онд 122.03 тэрбум доллароор үнэлэгдсэн бөгөөд 2023 онд 125.48 тэрбум доллар байсан бол 2030 он гэхэд 169.44 тэрбум доллар болж өсөх төлөвтэй байна

2023 оны байдлаар дараах компаниуд дэлхийн гэрэлтүүлгийн зах зээлийг тэргүүлж байна.

- SIGNIFY
- OSRAM
- Acuity Brands
- Panasonic
- GE Lighting
- OPPLE
- TOSHIBA
- Yankon
- FSL
- NVC Lighting
- Pak
- Unilumin
- TCL Lighting

Эрдэнэтэд үйлдвэрлэсэн LED гэрлийг дэлхийн зах зээлд гаргах зорилгыг битүүхэн агуулсан манай компани хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн ажлын байрны аюулгүй байдлыг хангасан, эрчим хүчний хэрэглээ, ашиглалтын зардлыг бууруулсан LED гэрэлтүүлгийн үйлдвэрлэлийг алхам алхмаар нэмэгдүүлж байгаагаас гадна Монгол инженерийн ур ухаанаар ургамлын гэрлийг туршиж үйлдвэрлэн зах зээлд нийлүүлээд байна.

02 Бизнесийн үйл ажиллагаа

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

Манай бүтээгдэхүүн Цахилгааны **хэрэглээ** болон **Ашиглалтын** зардлыг бууруулна.

Бид **гэрэлтүүлэг** болон **автоматжуулалтыг** цогцоор нь шийдвэрлэнэ






Бидний давуу тал

Манай бүтээгдэхүүн **Аюулгүй ажиллагаа**ны эрсдэлийг бууруулна

Буух эзэн **буцах хаягтай**

Хэрэглэгчийн хэрэгцээнд суурилсан шийдэл

Ургамлын гэрлийн шийдлийг гаргаж хэрэглээнд оруулав



Төмөр замын вагоны гэрлийн шийдлийг гаргаж эхний ээлжийн бүтээгдэхүүнийг нийлүүлэв




02 Бизнесийн үйл ажиллагаа

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

Хэрэглэгчийн хэрэгцээнд суурилсан шийдэл

Булган аймгийн Бүрэгхангай сумын гэрэлтүүлэг, захиргаа болон сургууль, цэцэрлэгийн байрны гэрэлтүүлгийн ажлыг харилцагчийн хүсэлд нийцүүлэн захиалгын дагуу, зургийг гарган ажлыг гүйцэтгэв.



02 Бизнесийн үйл ажиллагаа

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

Хэрэглэгчийн хэрэгцээнд суурилсан шийдэл

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын гэрэлтүүлгийн ажлыг захиалагчийн захиалгын дагуу гэрэлтүүлгийн шийдлийг гарган гүйцэтгэв.



Үсгэн санагчны зургийн байдал

№	Хэм: болон лого	Хэмжээ/Өндөр	Хэмжээ/Үзэл	Төрөл ширээг
1	ЗАСАГ ДАРГАЙН ТАМГИЙН ГАЗАР	70см	13,7мөтр	22
2		8000см	-	1

Үсгэн болон лого нэгтгэж суурь

№	Материалын нэр	Хэмжээ	Төрөл ширээг
1	Квадрат 45x30(мөтр) урт	33мөтр	25
2	Төгрөгний будаг/Хар	1мөтр	10



02 Бизнесийн үйл ажиллагаа

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

Бид бүтээгдэхүүнийхээ давуу талыг Монголдоо ганц байдаг гэрлийн лабораторийн туршилтаар баталгаажуулж байна. Гэрлийн лабораториа 2024 онд магадлан итгэмжлүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд ингэснээр олон улсын стандартад нийцсэн гэрэл, гэрэлтүүлгийг зах зээлд нийлүүлэх боломжтой юм.

Лабораторийн *SPEC-2000A Rapid Spectrum* төхөөрөмжийн талаар

Төхөөрөмжийн нэр: SPEC-2000A Rapid Spectrum Analysis System

Долгионы уртын хүрээ: 380нм~780нм

Долгионы уртын нарийвчлал: ±0.3нм

Өнгөний нарийвчлал: ± 0.0003

Гэрлийн урсгалын хүрээ: 0.01лм ~ 6.00×10⁵лм

Өнгөний температурын хүрээ: 1000K ~ 100000K

Хэмжилтийн хурд: 1ms ~ 5000ms 1.2

Туршилтын орчин, Температур: 25°C ±5°C

Чийгшил: RH 65% -иас бага


Гаралтын давтамжийн тохиргоо: 45.00~65.00Hz

Гаралтын хүчдэлийн тохиргоо: AC 0.0~300.0V

AC, DC, AC/DC дохиог хэмжих боломжтой



Лабораторийн туршилтаар хэмжих боломжтой үзүүлэлтүүд



Өнгөний үзүүлэлт

Өнгөний температур
Долгионы урт
Өнгө ялгах чадвар
Өнгөний хүрээ
Өнгөний координат

Оптик үзүүлэлт

Гэрийн урсгал
Цацрагийн урсгал
Эрчим хүчний үр ашгийн индекс
Эрчим хүчний ангилал

Цахилгааны үзүүлэлт

Хүчдэл
Гүйдэл
Чадал

02 Бизнесийн үйл ажиллагаа

Нийгмийн хариуцлага

Аймаг сумынхаа хөгжил дэвшилд зориулан бага ч болов хөрөнгө оруулалт хийх зорилгоор өөрсдийн боломжид тулгуурлан доорх ажлуудыг хийгээд байна.

Орхон аймгийн Урлагийн Уран эгшиг сургуульд 6ш гадна гэрэлтүүлгийн толгойг хүүхдүүдийн аюулгүй байдалд зориулан хандивлав.


Баян-Өндөр сумын Уртын гол багийн үсгэн хаягийг хийж бэлэглэв

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Цэцэрлэгт хүрээлэн, иргэдийн амарч зугаалах талбайд баг хамт олноороо 300ш мод тарив

Орхон аймгийн БОЭТ-ийн халдвартын тасагт гадна гэрэлтүүлгийн шон, толгой гэрэлтүүлгийн хамт бэлэглэв

Цахилгаан, эрчим хүчийг хэмнэх зорилгоор нарны сэргээгдэх эрчим хүчийг ашиглан үйлдвэрийн байрны зарим хэсгийн эрчим хүчийг хангах нарны толийг байршуулан ашиглахаар ажиллаж байна.

Уран эгшиг сургуулийн гэрэлтүүлэг



Уртын гол багийн хаяг



Цэцэрлэгт хүрээлэнд мод тарих үеэр



02 Бизнесийн үйл ажиллагаа

Гүйцэтгэх удирдлагын баг



Анд-Энерги ХК-ийн
Гүйцэтгэх захирал
Цэнд-Аюушийн
Гүррагчаа
Уулын цахилгаан
механик тоног
төхөөрөмжийн инженер,
Монгол улсын
мэргэшсэн инженер




Санхүү төлөвлөлтийн
алба хариуцсан
менежер Санхүүгийн
менежер
Пүрэвдоржийн
Бямбасүрэн
Даатгалын эдийн
засагч, Бизнесийн
удирдлагын магистр



Маркетинг, Борлуулалт
хариуцсан менежер
Мандахын Эрдэнэцэцэг
Үйлдвэрлэлийн
механикжуулалтын
инженер, Төрийн
удирдлагын
магистрантур



Захиргаа, аж ахуйн
алба хариуцсан
менежер Хүний
нөөцийн менежер
Энхболдын
Ариунсайхан
Нийгмийн ажилтан,
Хүний нөөцийн
менежментийн
магистрантур



Судалгаа хөгжил ба
Үйлдвэрлэлийн алба
хариуцсан менежер
Энхтуяагийн Нямгэрэл
Үйлдвэрлэлийн
автоматжуулалтын
инженер, Бизнесийн
удирдлагын магистр



Ерөнхий нягтлан
бодогч
Доржсүрэнгийн
Ундармаа
Нягтлан бодогч

02 Бизнесийн үйл ажиллагаа

Хүний нөөцийн бодлого



Манай компанийн үнэт нөөц болох хүний нөөцийн ихэнх хувийг залуучууд эзэлж байна. Тэр ч утгаараа хүний нөөцийн бодлого маань шинэ залуу үеийн ажиллах хүчний онцлогийг хүндэтгэн сэтгэл ханамжтай, бүтээмж өндөртэй ажилтнуудын нэгдлийг бий болгон ажиллахаар зорьж байна. Бид оршин байгаа газрын байршлаас үл хамааран орчин үеийн техник технологи, хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах зорилгоор хүний нөөцийг тасралтгүй сургаж хөгжүүлэх, туршлага чадвар судлуулах, мэдээ мэдээллээ хуваалцах ажлыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж байна.

Мөн ажилтнуудын оролцоонд суурилсан сэтгэл ханамжтай, аз жаргалтайгаар ажлаа хийдэг, хүндээ төвлөрсөн уян хатан шийдвэрүүдийг гаргадаг хүний нөөцийн бодлогыг баримтлан ажиллаж байна.




02 Бизнесийн үйл ажиллагаа

Сургалт, хөгжил

2023 онд бид хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтнуудын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, хувь хүний хөгжлийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор дараах сургалт, зөвлөх үйлчилгээнүүдэд хамрагдав



Санхүүгийн зөвлөх үйлчилгээний сургалтууд




HMT нэврүүлэх зөвлөх сургалтууд



GIZ Хүн бүр Коуч хандлагатай болох нь цуврал сургалт



Болор үйлсийн үндэс ТББ-тай хамтран бүх түвшнийг хамарсан, мөн ажилтны гэр бүлрүү чиглэсэн нийт 12 удаагийн хувь хүний хөгжлийн сургалт



Бүтээгдэхүүн танилцуулах, Цахилгаан техникийн онол сэдвүүдээр 2 удаагийн сургалт

EKF бүтээгдэхүүний танилцуулах сургалт


02 Бизнесийн үйл ажиллагаа

Үйлдвэрлэл, үйл ажиллагааны ололт амжилт

2023 онд манай залуу инженерүүд Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ус өргөх 1,2-р станцуудын хоорондох хяналт удирдлагын гранит-микро системийг шинэчлэн суурилуулж, тохируулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэв. Өөрөөр хэлбэл энэхүү ажил нь Орхон аймгийн айл өрх, албан байгууллагыг цэвэр усаар хангах аюулгүй, найдвартайгаар хангах үйл ажиллагаа юм.



Ургамлын гэрлийн шинэ шийдлийг гаргаж, хэрэглэгчдэд хүргэлээ.




02 Бизнесийн үйл ажиллагаа

Үйлдвэрлэл, үйл ажиллагааны ололт амжилт

Европын сэргээн босголтын хөгжлийн банкны “EBRD” дэмжлэгтэйгээр Санхүүгийн зөвлөх үйлчилгээ авч үйлдвэрлэлийн өртөг тооцох аргачлалаа шинэчлэн батлуулав. Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бүртгэлээ процессжуулж, санхүүгийн үйл ажиллагааны журмаа сайжруулан баталж үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэвшүүлэхээр ажиллаж байна.



Гүйцэтгэлийн төгөлдөршил ХХК-ийн зөвлөх үйлчилгээний гэрээгээр Бизнесийн зөвлөх н.Өлзийбуяантай хамтран ажиллаж компанидаа Нэгдсэн менежментийн тогтоолцоог нэвтрүүлэх эхний алхмуудаа амжилттай хэрэгжүүлж цаашид системтэйгээр нутагшуулахаар ажиллаж байна.



Орхон аймгийн ХАҮТ, ЗДТГ-аас зохион байгуулдаг Enrepreneur-2023 арга хэмжээнээс Авто зам, барилгын салбарын “Онцлох байгууллага”-аар шалгарлаа.




Build Mongolia-2023 арга хэмжээнд оролцож “Шилдэг ногоон технологи нэвтрүүлэгч байгууллага”-аар шалгарав.



02 Бизнесийн үйл ажиллагаа

Бидний харилцагчид



02 Бизнесийн үйл ажиллагаа

Бизнесийн үйл ажиллагааны биелэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэл			
		2020	2021	2022	2023
Үйлдвэрлэсэн гэрэлтүүлэг	Сая.төг	956.80	966.90	607.20	730.4
Шууд худалдааны борлуулалт		535.80	512.60	629.30	930.00
МАҮ-ний суурилуулалтын ажлын борлуулалт		653.60	403.70	848.20	469.52
Нийт борлуулалтын орлого		2.146.2	1.883.2	2.084.7	2.129.9
Борлуулалсан бүтээгдэхүүний өртөг		1312.4	1266.5	1400.2	946.3
Үйл ажиллагааны зардал		893.4	765	674.5	1145
Цэвэр ашиг		24.5	13.8	26.2	48.28
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо		25.731	21.914	12.443	11.638
Борлуулсан бүтээгдэхүүний тоо		37.243	21.690		
Үйлдвэрлэлийн хүчин чадал	шир	500-800	500-800	500-800	500-800
Ажил		8	17	20	13

02 Бизнесийн үйл ажиллагаа

Бизнесийн үйл ажиллагааны төлөвлөлт

2024 онд хүрэх зорилтууд

- Нэгдсэн менежментийн тогтолцоо нэвтэрсэн, үйл ажиллагаа тогтворжсон байна
- Сар бүрийн борлуулалтын орлогыг бүрдүүлэх төлөвлөлтийг гаргаж хэвшүүлсэн байна
- MNS IEC 60598-1:2020 стандартыг батлуулсан байна
- Зорилтот хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэх чадавх бүхий мэргэжлийн багийг бүрдүүлсэн байна
- Хэрэглэгчийн хэрэгцээг хангасан 2-3 бүтээгдэхүүний шийдэл боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна
- Санхүүгийн үзүүлэлтийг тухай бүр нарийвчлалтай хянах аргачлал нэвтэрсэн байна
- Хүний нөөцийг чадавхжуулсан байна



03 Байгаль орчин, нийгэм засаглал

Дэлхий дахины хувьд шийдвэрлэхэд хамгийн түвэгтэй асуудлын нэгдүгээрт эрэмбэлэгдэж байгаа дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд бидний оролцоо бага гэж тоомжиргүй хандах бус оруулж буй нөлөөгөө багасгах хүчин чармайлтыг бодитоор гаргах цаг болжээ.

Монгол Улсын нийт хүлэмжийн хийн ялгарлын 50.1 хувийг эрчим хүчний салбар, 49 орчим хувийг хөдөө аж ахуйн салбар, багахан хувийг аж үйлдвэр, хог хаягдал, барилгын салбар эзэлдгийг хүлэмжийн хийн ялгарлын тооллого судалгаагаар гаргажээ.

БОАЖЯ-ны тооцоолсноор 2024 онд хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар багасгахын тулд 9.2 сая тн нүүрсхүчлийн хийд тэнцэх хэмжээний хүлэмжийн хийг бууруулах шаардлагатай гэжээ.

Хүлэмжийн хийг багасгах олон улсын хүчин чармайлтад МУ төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажиллахын сацуу бид ч мөн адил багахан болов хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Лед гэрэлтүүлгийн хүлэмжийн хийн ялгарал нь ердийн улайсдаг эсвэл Компакт флюоресцент гэрлүүдээс хамаагүй бага байдаг.

Нарийвчилсан тооцооллоор улайсдаг чийдэнтэй ижил гэрэлтүүлгийг хангадаг нэг Лед чийдэн нь хүлэмжийн хийг 80% бага, CFL-гэрэлтүүлгээс 50%-иар хүлэмжийн хий ялгаруулдаг байна.

Бид 2023 онд нийт 12,418 ширхэг Лед гэрэл үйлдвэрлэн борлуулсан ба дээрх тооцооллоор дараах үр дүн гарч байна.

Үүнд:

№	Гэрэлтүүлгийн төрөл	Гэрэлтүүлгийн тоо ширхэг	Хүлэмжийн хий ялгаруулах хэмжээ	Хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих нэгж
1	Улайсах гэрэл	12,418	6 497 753	кг
2	CFL гэрэл	12,418	1 141 814	кг
3	Лед гэрэл	12,418	570 907	кг

Хүлэмжийн хийн ялгарлыг багасгахын тулд салхин болон усан цахилгаан станцыг олшруулж, барилгын дулааны алдагдал багасгах, эрчим хүчний хэмнэлтийг сайжруулж, автомашинд чанартай шатахуун хэрэглэх, малын тоо толгойг цөөлөх, бэлчээрийн менежментийг сайжруулах шаардлагатай.

Эрчим хүчний бага зарцуулалт нь цахилгаан станцуудын ачааллыг бууруулж, улмаар цахилгаан үйлдвэрлэхэд шатаж буй түлшний хэмжээг бууруулдаг.

Лед гэрэлтүүлгийн хамгийн байгаль орчинд ээлтэй талуудын нэг нь маш өндөр цахилгааныг гэрлээр хувиргадаг бөгөөд ихэнх тохиолдолд 90% хүртэл байдаг.

Энэхүү хувиргах өндөр үр ашиг нь хүрээлэн буй орчинд хамгийн бага дулаан алдагдлыг илтгэнэ.

04 Компанийн засаглал

Компанийн ерөнхий мэдээлэл

Оноосон нэр:

АНД-ЭНЕРГИ

Хэлбэр:

ХУВЬЦААТ КОМПАНИ

Регистрийн дугаар:

4385772

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ ХХК

Гаргасан хувьцааны тоо:

78,070,758


Тикер

AND

Үйл ажиллагааны чиглэл:

- **ГЭРЭЛ ГЭРЭЛТҮҮЛЭГ ҮЙЛДВЭРЛЭЛ**
- **ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ**
- **ЦАХИЛГААН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ**
- **ШУУД ХУДАЛДАА**


Хувьцаа эзэмшигчид



ҮЦТХТ ХХК-аас гаргасан 2023.04.04-ний өдрийн байдлаарх үнэт цаас эзэмшигчдийн судалгааны мэдээлэл

04 Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Өмнөх онтой харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Ц.Гүррагчаагийн эзэмшлийн хувь 0.1%-иар буурсан байна.

Хувьцаа эзэмшигч	2022 оны эцэс		2023 оны эцэс	
	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь
1 Т.Барс	12 908 375	16.5	12 908 075	16.5
2 Д.Мөнхбаяр	12 908 875	16.5	12 908 875	16.5
3 Г.Түвшин	12 908 375	16.5	12 908 375	16.5
4 Ц.Гүррагчаа	12 830 375	16.4	12 735 875	16.3

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Анд-Энерги ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм.



Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023.04.22 өдөр Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах үйлдвэрийн байранд цахим хэлбэрээр 66.8%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

- 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.
- 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг тус тус батлав.

04 Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөл компанийг удирддаг.

Анд-Энерги ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар шийдвэр гаргаж ажилладаг.

ТУЗ-ийн хурлаар жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, улирал тутам хуралдан төлөвлөгөөний биелэлтийг тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлэг өгч ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

2022 оны 4 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. ТУЗ-ийн даргаар Төмөрбатын Барс ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2024 онд дуусгавар болно.



**ТӨМӨРБАТЫН
БАРС**

ТУЗ-ийн ердийн гишүүн
бөгөөд ТУЗ-ийн дарга

2022 оноос Анд-Энерги ХК-ийн ТУЗ-ийн дарга
Хувьцааны эзэмшил: 16,5%



**ДАЛХААГИЙН
МӨНХБАЯР**

ТУЗ-ийн ердийн гишүүн

2018 оноос Анд-Энерги ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцааны эзэмшил: 16,5%



**ГАНХУЯГИЙН
ТҮВШИН**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т
автоматжуулалтын инженер
2018 оноос хойш Анд-Энерги
ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцааны эзэмшил: 16,5%

04 Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



**ЦЭНД-АЮУШИЙН
ГҮРРАГЧАА**

ТУЗ-ийн ердийн гишүүн

2018 оноос Анд-Энерги ХК-ийн Гүйцэтгэх захирал
Хувьцааны эзэмшил: 16,3%



**ЭРДЭНЭБАЯРЫН
МЯГМАРДОРЖ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

2022 оноос Анд-Энерги ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцааны эзэмшил: 0,00%



**ДАГВАПУНЦАГИЙН
АЛТАНГЭРЭЛ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

“АЦХ”-ийн Гүйцэтгэх захирал
2018 оноос хойш Анд-Энерги ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Хувьцааны эзэмшил: 0,4%



**МӨНХЖАРГАЛЫН
ГАНБАТ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Орхон аймгийн Худалдаа
аж үйлдвэрийн танхимд
Танхимын дарга

2018 оноос хойш Анд-
Энерги ХК-ийн хараат бус
гишүүн
Хувьцааны эзэмшил: 0,00%



**ДАШДАВААГИЙН
БОРГИО**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

2022 оноос Анд-Энерги ХК-ийн ТУЗ-ийн хараат бус
гишүүн
Хувьцааны эзэмшил: 0,006%



**ДҮҮСҮРЭНГИЙН
МӨНХБАТ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Азийн хөгжлийн банкинд
зөвлөх
2022 оноос хойш Анд-Энерги ХК-ийн ТУЗ-ийн хараат бус
гишүүн
Хувьцааны эзэмшил: 0,00%

04 Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан

ТУЗ нь 2023 оны эхний хагас жилд танхимаар, танхим-цахим хосолсон, цахим хэлбэрээр нийт 4 удаа хуралдаж, 11 тогтоол шийдвэр гаргасан ба хурлын ирц 89-100% байв.

	Огноо	Ирц	Шийдвэрлэсэн асуудал
1	2023.02.15 /ээлжит/	89%	<ol style="list-style-type: none">1. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай;2. Ногдол ашиг хуваарилах эсэхийг шийдвэрлэх тухай;3. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам батлах тухай;
2	2023.03.11 /ээлжит бус/	100%	<ol style="list-style-type: none">1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх тухай;2. 2023 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж, шийдвэр гаргах тухай;3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай;4. 2023 оны ТУЗ-ийн ажлын төлөвлөгөөг батлах тухай;
3	2023.03.17 /ээлжит бус/	89%	<ol style="list-style-type: none">1. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох эсэх тухай;
4	2023.06.19 /ээлжит/	100%	<ol style="list-style-type: none">1. 2023 оны бизнес төлөвлөгөөг сайжруулан батлах тухай;2. Эх үүсвэргүй аккредитив баталгааны эрх нээх, гэрээг сунгах тухай;3. Хувьцааны үнэ цэнэ нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах тухай;4. Бусад асуудал;
5	2023.09.24 /ээлжит/	88.9 %	<ol style="list-style-type: none">1. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох эсэх тухай;
6	2023.11.29 /ээлжит/	88.9 %	<ol style="list-style-type: none">1. Аудитын байгууллагыг сонгох тухай;

04 Компанийн засаглал

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Анд-Энерги ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог тус тус зохион байгуулан ажилладаг

АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, аудитын байгууллагыг сонгох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Аудитын хороо 2023 онд 4 удаа хуралдсан.

Бүрэлдэхүүн: Хорооны дарга Д.Мөнхбат

Хорооны гишүүд: Т.Барс, М.Ганбат

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, үйл ажиллагаанд үнэлэлт өгөх чиглэлээр хяналт, удирдлагын чиг үүргээ үр дүнтэй, улмаар компанийн бизнесийн зорилтдоо хүрэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Бүрэлдэхүүн: Хорооны дарга Д.Боргио

Хорооны гишүүд: Э.Мягмардорж, Д.Мөнхбат

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, компанид үр ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд компанийн ТУЗ-ийн гишүүд, компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тэдгээрийн цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлоход оршино.

Бүрэлдэхүүн: Хорооны дарга М.Ганбат

Хорооны гишүүд: Д.Боргио, Д.Мөнхбаяр

43 Компанийн засаглал

ТУЗ-ийн цалин урамшуулал

ТУЗ-ийн дарга болон нарийн бичгийн даргад сар бүр тогтмол цалин олгодог бөгөөд ТУЗ-ийн гишүүдэд ТУЗ-ийн хурал болон хороодын хуралд оролцсон ирцээс хамаарч улиралд нэг удаагийн цалин олгодог ба нэмэлт урамшуулал тус тус олгодоггүй. ТУЗ-ийн үндсэн цалингийн хэмжээнд ТУЗ-ийн 2022.05.15-ны өдрийн 22/09 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан.

ТУЗ-ийн гишүүн	Сарын үндсэн цалин (төг)	ТУЗ-ийн улирлын цалин (төг)	Олговол зохих нийт цалин (төг)	НДШ, ХХОАТ суутгал (төг)	Гарт олгосон нийт цалин
1 Т.Барс	2,500,000		30,000,000	5,997,000	24,003,000
2 Ц.Гүррагчаа	3,230,000	552,000	42,372,308.33	8,338,543.6	34,033,764.8
3 Д.Мөнхбаяр		552,000	2,025,840	352,258.4	1,673,581.6
4 Г.Түвшин		552,000	2,208,000	445,353.6	1,762,646.4
5 Д.Алтангэрэл		552,000	1,656,000	334,015.2	1,321,984.8
6 Э.Мягмардорж		552,000	2,208,000	389,328	1,818,672
7 М.Ганбат		552,000	2,208,000	445,353.6	1,762,646.4
8 Д.Боргио		552,000	2,208,000	205,344	2,002,656
9 Д.Мөнхбат		552,000	2,025,840	445,353.6	1,762,646.4

Дээр зааснаар тайлант оноос эхлэн Кодексийн шаардлагын дагуу ТУЗ-ийн цалингийн мэдээллийг нээлттэй, ил тод танилцуулж эхлэв.

04 Компанийн засаглал

Хувьцааны мэдээлэл

2023 онд компанийн 262,400 ширхэг хувьцаа, нийт 6,773,009 төгрөгийн үнэлгээтэйгээр арилжаалагдсан бөгөөд хувьцааны үнэ 23 төгрөгөөс 31 төгрөгийн хооронд хэлбэлзэж жилийн эцэст 31 төгрөгөөр хаагдсан байна.



Хөрөнгийн зах зээл ба хувьцааны үнэ

№	Мэдээлийн төрөл	Огноо	
		2022 оны эцэс	2023 оны эцэс
1	Гаргасан хувьцааны тоо	78 070 758	
2	Компанийн зах зээлийн нийт үнэлгээ (төгрөгөөр)	2,107,910,466 ₮	2,420,193,498 ₮
3	Арилжааны дүн (төгрөгөөр)	32,121,157 ₮	6,773,009 ₮
4	Арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	1,224,157	262,400
5	Дээд үнэ	57 ₮	31 ₮
6	Доод үнэ	23 ₮	22 ₮
7	Дундаж үнэ	26.2 ₮	25.8 ₮
8	Хаалтын үнэ (12 сарын 31-ний байдлаар)	27 ₮	31 ₮

Оролцогч талуудын тайлан мэдээ /2023.01.01-2023.12.31/

№	Симбол	Үнэт цаасны компанийн нэр	Арилжааны дүн (төгрөгөөр)
1	msx050	Ард Секюритиз ҮЦК	13,464,818₮
2	ubx071	Алтан хоромсог ҮЦК	6,000₮
3	msx041	Инвекор капитал ҮЦК	69,400₮
4	msx064	Таван Богд Капитал ҮЦК	2,800₮
5	msx061	Ти Ди Би Секьюритис ҮЦК	3,000₮

04 Компанийн засаглал

Ногдол ашгийн мэдээ

Ногдол ашгийн журмын дагуу Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлого баримталдаг. Компани дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:

Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргах ба санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор, хагас жилээр ногдол ашиг хуваарилах тохиолдолд хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэвэл энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хуралд заавал тайлагнана. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол шийдвэртээ хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр, ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргах ба Гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно. Ногдол ашиг төлөх өдрийг Компанийн батлагдсан бизнес төлөвлөгөөтэй уялдуулж, боломжит хугацааг харгалзан тогтооно.

Ногдол ашгийн хуваарьлалт /сүүлийн 5 жил/

Тайлант хугацаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн өдөр	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр
2019 он	-	-	-
2020 он	1.2	2020.02.15	2020.03.25
2021 он	-	-	-
2022 он	-	-	-
2023 он	0.8	2023.02.15	2023.04.04

04 Компанийн засаглал


Ногдол ашгийн мэдээ

Анд-Энерги ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2 сарын 15-ны өдрийн 23/02 тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 80 мөнгө буюу нийт 62,456,606.4 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ногдол ашгийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр буюу 2023 оны 4 сарын 4-ний байдлаар Анд-Энерги ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олгохоор болсон.

Компанийн зарласан ногдол ашгийг “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-иар дамжуулан Хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2023 оны 12 сарын 31-ний дотор олгосон.

Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг



Тайлант хугацаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн өдөр	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр
2019 он	-	-	-
2020 он	1.2	2020.02.15	2020.03.25
2021 он	-	-	-
2022 он	-	-	-
2023 он	0.8	2023.02.15	2023.04.04

05 Санхүүгийн тайлан

Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

АНД ЭНЕРГИ ХК (цаашид компани гэнэ)-ийн гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа би энэхүү хавсралтад үзүүлсэн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг батламжилж байна.



Ц.Гүррагчаа
Улаанбаатар хот, монгол улс Огноо:

A handwritten signature in black ink, appearing to be "D. Undarmaa".

Д.Ундармаа

05 Санхүүгийн тайлан

Аудитын дүгнэлт



“СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ”ХХК

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ЗӨВЛӨГӨӨ

Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот Улаанбаатар хот, Монгол улс, 16010, Утас: 11-976-99046494

Огноо:2024-02-27

№ 24/02

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

АНД ЭНЕРГИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд Дүгнэлт

Бид 2023 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн АНД ЭНЕРГИ ХК компанийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар АНД ЭНЕРГИ ХК компанийн 2023 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилууулж (эсвэл эдгээрийн талаар үнэн бөгөөд зөв ойлгоц өгч) байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

05 Санхүүгийн тайлан

Аудитын дүгнэлт

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үүнээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохимжтой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогч

Гүйцэтгэх захирал

Монгол Улс, Улаанбаатар хот
Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв
501 тоот



Ч.ЭНХЧИМЭГ

Утас: 976 – 9904 6494; 86030388

05 Санхүүгийн тайлан

Санхүү байдлын тайлан

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН			
2023 ОНЫ 12 САРЫН 31	Тэмдэглэл	22.12.31	23.12.31
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгөн хөрөнгө	4	9,857,928.02	53,124,371.60
Дансны авлага	5	630,103,151.61	745,868,057.55
Татвар ба НДШ-ийн авлага	6	575,153.54	311,240.06
Бусад авлага	7	65,423,403.10	69,983,287.49
Бараа материал	8	560,936,099.26	710,181,688.96
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9	60,287,115.17	58,629,263.28
Эргэлтийн хөрөнгийн дүн		1,327,182,850.70	1,638,097,908.94
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	10	1,571,727,566.43	1,542,829,459.18
Биет бус хөрөнгө	11	65,788,083.83	64,922,131.76
Биологийн хөрөнгө		6,500,000.00	-
Үндсэн хөрөнгийн дүн		1,644,015,650.26	1,607,751,590.94
Нийт хөрөнгө		2,971,198,500.96	3,245,849,499.88
ӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг	12	90,529,970.39	23,557,257.06
Цалингийн өглөг	13	-	17,052,647.26
Татварын өр	14	55,920,708.15	102,434,043.48
НДШ-н өглөг	15	10,294,698.62	13,018,098.05
Богино хугацаат зээл	16	469,322,129.93	926,734,987.77
Хүүний өглөг	17	3,132,505.07	5,353,048.26
Урьдчилж орсон орлого	18	2,112,480.00	1,515,000.00
Урт хугацаат зээл	19	241,683,706.60	72,149,080.75
Өр төлбөрийн дүн		872,996,198.76	1,161,814,162.63
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувийн өмч	20	78,070,758.00	78,070,758.00
Нэмж төлөгдсөн капитал	21	1,470,540,877.00	1,470,540,877.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22	264,224,371.82	264,224,371.82
Хуримтлагдсан ашиг		285,366,295.38	271,199,330.43
Эздийн өмчийн дүн		2,098,202,302.20	2,084,035,337.25
Нийт эздийн өмч ба өр төлбөр		2,971,198,500.96	3,245,849,499.88

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



05 Санхүүгийн тайлан

Орлогын дэлгэрэнгүй тайлан

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН			
2023 ОНЫ 12 САРЫН 31			
Үзүүлэлт	Тэмдэглэл	22.12.31	23.12.31
Борлуулалт	23	2,084,776,060.63	2,129,913,049.36
ББӨ	24	1,400,284,283.13	946,306,003.23
Нийт ашиг		684,491,777.50	1,183,607,046.13
Хүүгийн орлого	25	-	201,908.73
Бусад орлого	26	18,111,719.54	20,003,256.00
Борлуулалт, маркетингийн зардал	27	132,175,306.34	53,680,505.86
Ерөнхий ба удирдлагын зардал	28	438,777,416.12	900,561,534.52
Санхүүгийн зардал	29	74,790,166.70	157,400,558.62
Бусад зардал	30	28,866,509.27	39,327,584.61
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	31	2,864.73	100.98
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз	32	1,433,160.52	2,018,255.83
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз гарз		(287,475.73)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг		29,142,648.13	54,860,384.06
Орлогын татварын зардал	33	2,914,264.82	5,368,744.74
Татварын дараах ашиг		26,228,383.31	49,491,639.32
Бусад олз (гарз)	34	-	(1,201,997.87)
Орлогын нийт дүн		26,228,383.31	48,289,641.45

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



05 Санхүүгийн тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		
2023 ОНЫ 12 САРЫН 31	22.12.31	23.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	2,119,212,437.85	2,271,067,475.89
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,303,709,376.58	2,022,424,758.51
Бусад мөнгөн орлого	815,503,061.27	248,642,717.38
Мөнгөн зарлагын дүн	2,332,283,589.55	2,451,026,444.36
Ажилчдад төлсөн	201,052,385.24	207,149,858.08
Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн	126,734,625.65	145,877,526.27
Бараа материал худалдан авахад төлсөн	1,202,909,839.19	987,726,391.24
Ашиглалтын зардалд төлсөн	24,181.81	16,868,275.27
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,482,512.81	8,482,934.55
Хүүний төлбөрт төлсөн	71,657,661.63	152,981,170.36
Татварын байгууллагад төлсөн	133,903,452.63	164,665,586.96
Бусад мөнгөн зарлага	587,518,930.59	767,274,701.63
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	(213,071,151.70)	(179,958,968.47)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	-	201,908.73
Хүлээн авсан хүүгийн орлого	-	201,908.73
Мөнгөн зарлагын дүн	202,201,673.84	183,664,993.37
Бусдад олгосон зээл урьдчилгаа	202,201,673.84	183,664,993.37
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	(202,201,673.84)	(183,463,084.64)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	897,508,935.33	1,038,034,376.44
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	897,508,935.33	1,038,034,376.44
Мөнгөн зарлагын дүн	485,666,693.10	631,345,879.75
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	485,666,693.10	572,012,115.67
Төлсөн ногдол ашиг	-	59,333,764.08
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	411,842,242.23	406,688,496.69
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,430,583.31)	43,266,443.58
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,288,511.33	9,857,928.02
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,857,928.02	53,124,371.60

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

05 Санхүүгийн тайлан

Өмчийн өөрчлөлтийн тайлан

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН					
2023 ОНЫ 12 САРЫН 31					
Үзүүлэлт	Эздийн өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт
2021 оны 12 сарын 31 үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	258,916,525.21	2,071,752,532.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	221,386.86	221,386.86
Залруулсан үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	259,137,912.07	2,071,973,918.89
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	26,228,383.31	26,228,383.31
2022 оны 12 сарын 31 үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	285,366,295.38	2,098,202,302.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	285,366,295.38	2,098,202,302.20
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	48,289,641.45	48,289,641.45
Зарласан ногдол ашиг	-	-	-	(62,456,606.40)	(62,456,606.40)
2023 оны 12 сарын 31 үлдэгдэл	78,070,758.00	1,470,540,877.00	264,224,371.82	271,199,330.43	2,084,035,337.25

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



Тэрэлтэй
амьдралгаа



f And Energy
f Анд-Энерги ХК нэрийн дэлгүүр
@ andenergyofficial
@ andenergyofficial
x Mandenergy59001
v ANDEnergymongolia

🌐 andenergy.mn
☎ +976 7771 1010
✉ sales.andenergy@gmail.com
📍 Орхон Аймаг, Баян-Өндөр сум,
Уртын гол баг, Баянзам 3-4,
6 тоот, Erdenet, Mongolia

ГЭРЭЛТЭЙ АМЬДАРЪЯ

AND ENERGY JSC